

ТАРИАЛАНГИЙН БУС НУТГИЙН БЭЛЧЭЭРИЙН ТАЛХЛАГДАЛ, УРГАМЛАН НӨМРӨГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА

(Дархан-Уул аймгийн Орхон сумын жишээн дээр)

Э. Үүрийнцолмон, Н. Золзаяа


ШУА-ИИН ГАЗАРЗҮЙ-ГЕОКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ГАЗРЫН НӨӨЦ, ГАЗАР АШИГЛАЛТЫН САЛБАР

E-mail: iuree0330@yahoo.com

Оршил

Малчид бэлчээрээ улирлын байдлаар дөрвөн хэсэгт хувааж нүүдлийн аргаар бэлчээр ашиглалтыг зохицуулж ирсэн түүхэн уламжлалтай бөгөөд энэ нь нэг талаас бэлчээр нутгийн экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, ногдоо талаас мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрсдлээс хамгаалах нэг үндсэн арга байжээ. Монголчууд бэлчээрийг зөвхөн ургамал талаас нь бус газрын хотгор гүдгэр, хөрс, ургамал, уур амьсгал, ус, ан амьтан гэсэн байгалийн цогц нэгдмэл орчныг бэлчээрийн экологийн түвшинд авч үзэх бөгөөд бэлчээр ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зөв хослуулж ирсний үр дүн юм (С. Цэрэндаш, 2013). Бэлчээрийг он удаан жил сэлгээгүй ашиглаж, олон тооны мал бэлчээх, мэрэгчид олшрох зэрэг нь бэлчээрийн ургамлан нөмрөгийг өөрчилж, урьд өмнө байгаагаас нь эрс өөр шинж чанартай шинэ ургамлын бүлгэмдлүүдийг бий болгодог (О. Чогний, 2018). Бэлчээрийн ургамалжилт нь бэлчээрийн талбайн бүтээмж, тогтвортой байдлыг үнэлэх хамгийн чухал хүчин зүйл болдог (Sergelenkhuu J., 2012). Ургамлан нөмрөгийн төлөв байдлын өөрчлөгдэл сүүлийн жилүүдэд уур амьсгалын хуурайшил, зохисгүй үйл ажиллагаанаас хамаарч цөлжилтэнд өртөх малын хөлөөр талхлагдах зэрэг сөрөг нөлөөгөөр ургамлын төрөл зүйл багасах болсон байна. Малыг хэт олноор удаан хугацааны туршид нэг дор давтан бэлчээнсээр ургамлан нөмрөг өөрчлөгдөн, тэжээлийн чанар муутай ургамал ихсэж, малд идэмж сайн ургамлын тоо цөөрч, хөрсний өнгөн хэсэг нягтарч, бүтцээ алдан тоосорхог болох үйл явцыг бэлчээрийн талхлагдал гэж үздэг байна (О. Чогний, 2018). Бэлчээрийн зонхилогч зүйлүүд багасаж өвслөг ургамал сөөгөөр солигддог (Wang W., 2000). Доройтлын зэрэглэл малын тоо толгойтой шууд хамааралтай (Zhao, H. L., 2005) бөгөөд чанартай тэжээлийн ургамал багасаж, мал муу иддэг бусад зүйлүүд нэмэгддэг гэсэн судалгаанууд байдаг.

Судалгааны талбай



Зураг 1. Судалгаанд хамрагдааж буй сумын байршил

Орхон сумын нутаг дэвсгэр нь монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай Хэнтийн улархаг их муж Сэлэнгэ, Орхонуу сав дахь бэсрэг уулсын тойрогт хамрагдаж Орхон голын хөндийд байрлана. Орхон сумын газрын гадарга нь далайн түвшнээс дээш 620-1192 м өндөрт орших ба Орхон голын хөндийг даган зүүн хойноос баруун урагш сунасан тахир хэлбэр дүрстэй.

Судалгааны талбай болох Дархан-Уул аймгийн Орхон суманд хэвийн, сүл, дунд зэрэг, хүчтэй талхлагдсан зэрэг үзүүлэлтүүдийг төлөөлж чадахуйц бэлчээрийг сонгож, Браун-Бланкын (1964) ургамлын судалгааны аргазүйг ашиглан 1x1 m² талбайд бүлгэмдэл өөрчлөгдхө бүрт бичиглэл хийж, нийт 36 ургамлан бичиглэл хийсэн. Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох өрөнхий шаардлага болох MNS 5546:2005 стандартад үндэслэн талхлагдлын зэрэг тогтоосон. 0.5x0.5 m² талбайгаас ургамлын дээж авч, лабораторийн нөхцөлд 60°C-т 48 цаг хатааж ургацыг тодорхойлсон. В.И.Грубов (2008) боловсруулсан ургамлыг танъж тодорхойлох аргазүйг ашиглаж ургамлын зүйлүүдийг тодорхойлсон.

Аргазүй

Үр дүн, хэлэлцүүлэг

Орхон сум нь нийслэл Улаанбаатар хотоос 275 км, аймгийн төвөөс 45 км зайд байрладаг, нийтдээ 44177.0 га талбай бүхий газрыг 35 төрлөөр ашигладаг байна. Үүнээс 13 төрөл нь хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглагдаж байна. Нийт сумын 87.0 хувь буюу 38436.7 га талбайг хөдөө аж ахуйн газар эзэлж байна.

Бэлчээрийн ургац, зүйлийн бүрэлдэхүүн

Бэлчээрлэлт нь ургамлын ургах чадварыг сурлуулдаг (Sergelenkhuu J., 2012) ба ургамлан бүлгэмдлийн тэсвэрлэх чадвар биомасс буурдаг (Chen, Z. Z., 2003). Зүйлийн бүрэлдэхүүн, ургацыг мэдсэнээр тодорхойлох боломжтой.




График 1. Бэлчээрийн ургац, зүйлийн тооны өөрчлөлт

Сумын хэмжээнд хэвийн болон талхлагдсан бэлчээрийн ургац, зүйлийн тоог харьцуулан үзэхэд хэвийн бэлчээрт ургац 4.1 ц/га, зүйлийн тоо 1 m² талбайд 8 байхад талхлагдсан бэлчээрт 1.3 ц/га, зүйлийн тоо 4 болон буурч байгаа нь өмнөх судалгаануудтай дүйж байна.

- Орхон сум нь нийт 33898.9 га бэлчээрийн талбайтай. Үүний 19.6 хувь нь дундаж өндөр болон нам бэсрэг уулын, 55.7 хувь нь тал хээр, 24.7 хувь нь бүс дундын голын хөндийн бэлчээрт хамаарч байна.
- Нийт бэлчээрийн 42.4 хувь нь талхлагдаагүй, 57.6 хувь нь ямар нэг хэмжээгэр талхдагдсан байна. Талхлагдаагүй бэлчээр нь дундаж өндөр, нам бэсрэг уулын бэлчээр байхад талхлагдалд өртөөд байгаа бэлчээр нь тал хээр болон бүс дундын голын хөндий, нам хотосын бэлчээр байгаа нь жилийн ихэнх хугацаанд голын дагуу олон мал бэлчдэгтэй холбоотой байж болох юм.
- Хүчтэй талхлагдсан бэлчээрийн ургамлын зүйлийн тоо багасаж, малын идэмж муу ургамлын зүйлийн тоо ихсэж байна. Хэвийн бэлчээрээс сүл талхлагдсан бэлчээрлүү шилжихэд зүйлийн тоо өөрчлөгдөөгүй боловч дунд зэрэг талхлагдсан бэлчээрт шилжихэд ургац болон зүйлийн тоо буурч байна.


Ном зүй

- Болчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох өрөнхий шаардлага стандарт MNS 5546:2005
- Sergelenkhuu Jambal, Takashi Otoda, Yoshihiro Yamada, Undarmaa Jamsran, Keiji Sakamoto, and Ken Yoshikawa, 'Effect of Grazing Pressure on the Structure of Rangeland Plant Community in Mongolia', Journal of Arid Land Studies, 22 (2012), 235-38.
- Zhao, H. L., Zhao, X. Y., Zhou, R. L., Zhan, T. H., and Drake, S. Desertification processes due to heavy grazing in sandy grassland, Inner Mongolia. *Journal of Arid Environments* 62, (2005). 309–319.
- Wang, S. P., Li, Y. H., Wang, Y. F., and Han, Y. H. The succession of *Artemisia frigida* grassland and multivariation analysis of different stocking rates in Inner Mongolia. *Acta Ecologica Sinica* 6, (1998). 299–306. [In Chinese]

Хүснэгт 1. Экологийн хэв шинжүүдийн талхлагдлын зэрэглэл

№	Экологийн хэв шинж	Талхлагддад орсон газар		Үүнээс					
		Талбай, га	Эзлэх хувь	Сул талхлагдсан		Дунд зэрэг талхлагдсан		Хүчтэй талхлагдсан	
		Талбай, га	Эзлэх хувь	Талбай, га	Эзлэх хувь	Талбай, га	Эзлэх хувь	Талбай, га	Эзлэх хувь
1	Дундаж өндөр болон нам бэсрэг уул	-	-	-	-	-	-	-	-
2	Тал хээр	11140.1	32.9	2058.1	6.1	7873.6	23.2	1208.4	3.6
3	Бүс дундын голын хөндий, нам хотос	8373.0	24.7	276.3	0.8	1699.7	5.0	6397.0	18.9
	Нийт	19513.1	57.6	2334.4	6.9	9573.3	28.2	7605.4	22.4

Хүснэгтээс үзэхэд Орхон сумын талхлагдсан бэлчээрийг талхлагдлын зэрэглэлээр нь ангилж үзэхэд нийт талхдагдсан бэлчээрийн 2334.4 га буюу 6.9% сүл, 59573.2 га буюу 28.2% дунд зэрэг, 7605.4 га буюу 22.4% хүчтэй байна. Тал хээрийн бэлчээрийн 2058.1 га буюу 6.1% сүл, 7873.6 га буюу 23.2% дунд зэрэг, 1208.4 га буюу 3.6% хүчтэй талхлагдсан байна. Бүс дундын голын хөндий, нам хотсын бэлчээр 276.3 га буюу 0.8% сүл, 1699.7 га буюу 5% дунд зэрэг, 6397.0 га буюу 18.9% хүчтэй талхлагдсан байна.



Зураг 2. Орхон сумын бэлчээрийн талхлагдал

Дүгнэлт

- Орхон сум нь нийт 33898.9 га бэлчээрийн талбайтай. Үүний 19.6 хувь нь дундаж өндөр болон нам бэсрэг уулын, 55.7 хувь нь тал хээр, 24.7 хувь нь бүс дундын голын хөндийн бэлчээрт хамаарч байна.
- Нийт бэлчээрийн 42.4 хувь нь талхлагдаагүй, 57.6 хувь нь ямар нэг хэмжээгэр талхдагдсан байна. Талхлагдаагүй бэлчээр нь дундаж өндөр, нам бэсрэг уулын бэлчээр байхад талхлагдалд өртөөд байгаа бэлчээр нь тал хээр болон бүс дундын голын хөндий, нам хотосын бэлчээр байгаа нь жилийн ихэнх хугацаанд голын дагуу олон мал бэлчдэгтэй холбоотой байж болох юм.
- Хүчтэй талхлагдсан бэлчээрийн ургамлын зүйлийн тоо багасаж, малын идэмж муу ургамлын зүйлийн тоо ихсэж байна. Хэвийн бэлчээрээс сүл талхлагдсан бэлчээрлүү шилжихэд зүйлийн тоо өөрчлөгдөөгүй боловч дунд зэрэг талхлагдсан бэлчээрт шилжихэд ургац болон зүйлийн тоо буурч байна.

- Орхон сум нь нийт 33898.9 га бэлчээрийн талбайтай. Үүний 19.6 хувь нь дундаж өндөр болон нам бэсрэг уулын, 55.7 хувь нь тал хээр, 24.7 хувь нь бүс дундын голын хөндийн бэлчээрт хамаарч байна.
- Нийт бэлчээрийн 42.4 хувь нь талхлагдаагүй, 57.6 хувь нь ямар нэг хэмжээгэр талхдагдсан байна. Талхлагдаагүй бэлчээр нь дундаж өндөр, нам бэсрэг уулын бэлчээр байхад талхлагдалд өртөөд бай